



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх,  
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах  
хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.18, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/11 дүгээр тогтоолоор батлагдсан Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.1.3, 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Дүүргийн Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрх зүй, төрийн байгуулалтын хороо (Д.Баттөр)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МОНХГЭРЭЛ

1235610023

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 06 -ны өдрийн  
106 дугаар тогтоолын хавсралт

Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл,  
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр

### Нэг.Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Эрх зүйн үндэслэл: Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 61 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/11 дүгээр тогтооолоор батлагдсан Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.1.3, 3.1.4 дэх заалт нь төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үндэслэл болно.

Төрийн байгууллагын болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудаас тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга зам болон сургалт, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох талаар судалгаа авсан бөгөөд 228 албан хаагч буюу нийт 60 хувь нь хамрагдсан байна.

Үг судалгаанд оролцогчдын 32% нь 1-5 жил, 25.4% нь 6-11 жил, 19.7% нь 12-17 жил, 17.5%, 17-25 жил нь 5.3%, 25-аас дээш жил ажилласан албан хаагчид байна.

Судалгаанд оролцогчдын 13.6% нь Удирдлагын академийн сургалтад (сертификаттай) 13.6 % нь боловсролын зэрэг буюу мэргэжлээ дээшлүүлэх сургалтад, 34.6% нь нийслэлээс зохион байгуулж буй сургалтад, 46.9% нь бусад сургалтад хамрагдсан байна.

Сургалтын талаарх нээлттэй асуулгад олонх буюу 86 албан хаагч мэргэжлийн чиглэлээрх сертификаттай танхимын сургалтыг илүү үр дүнтэй гэж үзсэн байна.

Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааны талаарх санал асуулгад судалгаанд оролцогчдын 24% нь мөнгөн тусламжид, 24.1% нь түлээ нүүрсний хөнгөлөлтөд, 14% нь орон сууцны дэмжлэгт, 44.7% нь бусад дэмжлэг туслалцаанд хамрагдсан гэж хариулсан байна.

Цаашид үзүүлэх дэмжлэг туслалцаа, хэрэгцээний саналд:

- Дүүрэгт орон сууц худалдан авахад мөнгөн дэмжлэг үзүүлэх;
- Орон сууц болон бүтээн байгуулалтын ажлыг хурдан хугацаанд ашиглалтад оруулах;
- Цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны нөхцөл, тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Төрийн тусгай болон багш, орон нутгийн өмчит байгууллагын албан хаагчдад орон нутагт 5 жил ажилласны мөнгөн урамшуулал олгох саналыг дэвшүүлсэн байна.

Хөтөлбөрийг батлуулах бэлтгэл ажлын хүрээнд 2025 онд дүүрэгт шаардлагатай ажил мэргэжил болон сул орон тооны судалгааг 17 аж ахуйн нэгж байгууллагаас авч нэгтгэн үзэхэд ажлын байрны 73 сул орон тоо байна. Үүнд:

- Төрийн захиргаа- 5
- Төрийн тусгай-2
- Төрийн үйлчилгээ-16

- Бусад-8
- Боловсрол -13
- Эрүүл мэнд -11
- Дэд бүтэц -18

Дүүрэгт оршин суух хаягийн бүртгэлтэй оюутны судалгааг гаргахад эрүүл мэнд-19, боловсрол-13, хууль, эрх зүй-8, соёл, урлаг-6, санхүү, эдийн засаг-13, программ, хангамж-10, аялал жуучлал-2, хэл судлал, орчуулагч-5, сэтгэл зүйч-5, төмөр зам-8, дэд бүтэц-10, хөдөө, аж ахуй-3, батлан хамгаалах-2 мэргэжлээр нийт 112 оюутан залуучууд суралцаж байгаа бөгөөд тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлж, шаардлагатай ажил мэргэжлээр ажлын байрны сул орон тоог нөхөх саналыг дэвшүүлсэн байна.

#### Хоёр.Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, ажиллах нөхцөлийг сайжруулах, үр бүтээлтэй, тогтвортой суурьшилтай, идэвх санаачилгатай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, бодитой дэмжлэг үзүүлэн нийгмийн баталгааг хангахад чиглэгдэнэ.

#### Гурав.Хөтөлбөрийн зорилт

3.1.Төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн системтэй үе шаттай сургалтад хамруулан, тасралтгүй хөгжих нөхцөлийг бүрдүүлэн, нэн шаардлагатай ажил мэргэжлээр суралцагсдыг тэтгэлэгт хамруулж дэмжлэг үзүүлэх

3.2.Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах замаар албан хаагчдын сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

#### Дөрөв. Хэрэгжүүлэх зарчим

4.1.Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- 4.1.1.Ил тод байх;
- 4.1.2.Нээлттэй байх;
- 4.1.3.Бодитой байх;
- 4.1.4.Шударга байх.

#### Тав.Төрийн албан хаагчийн сургалт

5.1.Төрийн захиргааны албан хаагчийн хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан зохих мэргэшүүлэх багц сургалтад хамруулах

5.2.Албан хаагчийн ур чадвар дадлага туршлагыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дотоод гадаадын мэргэжилтэн багш нарыг урьж ажлын байранд онолын болон дадлага сургалт зохион байгуулах

5.3.Албан хаагчийг гүйцэтгэж байгаа ажил мэргэжлийн чиглэлээр гадаад улс оронд зохион байгууллагдах сургалт, семинар, зөвлөгөөнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх

5.4.Байгууллага, албан хаагчдын сургалт хийх чадавх, мэдлэгээ бусдад түгээх санал санаачилгыг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, үр дүн бүхий шилдэг туршлагыг сурталчлах урамшуулах

5.5.Дүүргийн нэн шаардлагатай ажил мэргэжлийн судалгаанд үндэслэн сул орон тоог нөхөх зорилгоор бакалаврт суралцагсдыг тэтгэлэгт хамруулж дэмжлэг үзүүлэх

## Зургаа.Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа

6.1.Төрийн байгууллагын барилга байгууламж шинээр барих, засварлах, орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тавилга, эд хогшлоор хангах ажлыг үе шаттай төлөвлөн шийдвэрлэх

6.2.Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүйн нөхцөлийг сайжруулах, ажлын байрны хэвийн нөхцөлийг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх

6.3.Албан хаагчдыг дотоодын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх

6.4.Ганц бие эцэг, эх болон шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг тусламж үзүүлэх

6.5.Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах нөхцөлийг судлан, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

6.6.Дүүргийн боловсрол, эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай мэргэжлээр ажиллаж байгаа багш, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвортой, суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах, бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэн орон нутагт ажилласны нэмэгдлийг сар бүр тооцож олгох

## Долоо.Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

7.1.Энэхүү хөтөлбөрийг 2025-2028 оныг дуусталх хугацаанд хэрэгжүүлнэ.

7.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.2.1.Орон нутгийн төсвийн хөрөнгө

7.2.2.Байгууллагын төсөв

7.2.3.Гадаад дотоодын хандив, тусламж

7.2.4.Бусад эх үүсвэр

## Найм.Хөтөлбөрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1.Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаад чиглэгдэнэ.

8.2.Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр гаргана.

8.2.1.Зохион байгуулсан сургалтын тоо, зардлын хэмжээ

8.2.2.Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо, зардлын хэмжээ

8.2.3.Гадаад улсад туршлага судалсан төрийн албан хаагчийн тоо, зардлын хэмжээ

8.2.4.Бакалаврын тэтгэлэгт хамруулсан суралцагчийн тоо, зардлын хэмжээ

8.2.5.Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээний тоо, зардлын хэмжээ

8.2.6.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан албан хаагчийн тоо, зардлын хэмжээ

8.2.7.Ганц бие эцэг, эх болон шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд үзүүлсэн дэмжлэгийн тоо, зардлын хэмжээ

8.2.8.Орон сууцаар хангагдсан төрийн албан хаагчийн тоо, зардлын хэмжээ

8.2.9.Орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон албан хаагчийн тоо

## Ес.Хөтөлбөрийн үр дүн

9.1.Төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар, хандлага зан үйлийн түвшин нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж, төрийн алба ажлын дадлага туршлагатай мэргэшсэн албан хаагчаар бүрдсэн байна.

9.2.Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжид бодит ахиц дэвшил гарч, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллан төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна.